



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/142

Ховд

Хөрөнгө оруулалтын ажлуудыг эрчимжүүлэх  
төлөвлөгөө баталж, үр дүнг сайжруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "а", 2019 оны төсвийн тухай хууль, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8/04 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, Орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан болон бусад сангуудын хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Дээрх төлөвлөгөөнүүдэд тусгагдсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлд холбогдох яам, агентлаг, сум, байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, инженер хайгуулын судалгаа, зураг төсөв, техникийн нөхцөл, баригдах газрыг аймаг, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж, хууль журамд нийцүүлэн 2019 оны 03 дугаар сард багтаан худалдан авах ажиллагааг эхлүүлж, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж, гэрээний хугацаанд нь чанартай хэрэгжүүлэхийг аймгийн Засаг даргын орлогч Т.Жаргалсайхан, Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/, сумдын Засаг дарга, албан байгууллагуудын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

3. 5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын явцад байнгын хяналт, шалгалт хийж, хугацаанд нь гүйцэтгэхэд холбогдох дэмжлэг үзүүлж, явцын мэдээллийг тухай бүр нь Засаг даргын Зөвлөлд танилцуулж, ажиллахыг аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /С.Гантөмөр/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /П.Эрдэнэчулуун/, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга /Б.Баярсүх/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

02.00652

6. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, хэрэгжилтийн явцын мэдээллийг сар бүрийн 05-ны дотор Засаг даргын Зөвлөлд танилцуулж, үр дүнг нэгтгэн тайлан мэдээг улирал бүрийн сүүлийн сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ